



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан.
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/09/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГЭРЭЛТЭЙ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Л.НЯМСҮРЭН ТАНАА

2022.02.25 № 140
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАР ХҮҮГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР 009020243

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>48,838,061.92</u>	<u>297,341,076.80</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>248,493,280.90</u>	<u>406,688,007.94</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>297,331,342.82</u>	<u>704,029,084.74</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>297,331,342.82</u>	<u>704,029,084.74</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>297,331,342.82</u>	<u>704,029,084.74</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	383,344,689.54	1,105,564,709.51
	Үйл ажиллагааны зардлын дүн	315,889,889.64	698,866,967.59
	Үйл ажиллагааны үр дүн	<u>67,454,799.90</u>	<u>406,697,741.92</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>67,454,799.90</u>	<u>406,697,741.92</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,876,542.92	297,331,342.82
	Тайлант оны үр дүн	67,454,799.90	406,697,741.92
	Эцсийн үлдэгдэл	297,331,342.82	704,029,084.74
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>327,050,979.00</u>	<u>681,820,253.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>312,127,379.00</u>	<u>673,173,453.00</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>14,923,600.00</u>	<u>8,646,800.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(14,923,600.00)</u>	<u>(8,646,800.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	-	-
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	317,888,200.00	681,820,253.00
	Урсгал зардал	317,888,200.00	673,173,453.00
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Орон нутгийн төсвөөс	317,888,200.00	622,984,670.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

- Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь: “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг шуурхай чанартай хүргэснээр иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх. зонхилон тохиолдох өвчлөл. түүний хүндрэл. нас баралтыг бууруулах”-д оршино.
- Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлсон:
- Аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтарч ажиллана.
- Эрүүл мэндийн тусалж үйлчилгээний чанар. үр дүнг дээшлүүлж. иргэдийн чирэгдлийг бууруулна.
- Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах сургалтад хамжуулж. чадавхжуулах ажлыг зохион байгуулна..

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа. санхүү. нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол тус тус шинээр мөрдөгдөж эхэлсэн байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно

Дөрөв. Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга. нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хөрөнгийн дүнгээс санхүүгийн тайлан дахь өмчийн дүн 181,607,547.40 төгрөгөөр илүү зөрүүтэй дүнг нэмэгдүүлж шийдвэрлэсэн эсэхийг нарийвчилсан горим сорилыг дараагийн аудитаар хэрэгжүүлнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,326.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,805.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 108.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,412.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

1. Тайлант хугацаанд Орлого санхүүжилтийг орлого үр дүнгийн тайланг мөнгөн хөрөнгийн журналаас хөөн шалгахад орлогын данснаас ЭМДЕГ-аараас Ковидын гэрийн эмчилгээний болон дархлаажуулалтын санхүүжилтын авлага 2,500.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэнийг дансны бичилтийн алдааг залруулав.
2. Нийгмийн Даатгалын Хэлтэсээс листний өглөгийн төлбөрт шилжүүлсэн 305.9 мянган төгрөгийг орлогын дансанд бүртгэсэн дансны бичилтийн алдааг залруулав
3. Тайлант хугацаанд 10 албан хаагчид нийт 20.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосонд төлбөрийн акт тогтоов
4. Эмийн тайлангийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, гүйцэтгэлийн тайлан баталгаажилтгүй 88.0 мянган төгрөгийн эм зарцуулсныг төлбөрийн акт тогтоов.
5. Сургалтын төлбөрт шилжүүлсэн 240.0 мянган төгрөг тушаал шийдвэргүй, гэрээ дүгнээгүй, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.
6. Анхан шатны хүчин төгөлдөр бус и-баримтгүй/ Бизнес клуб ХХК-иас/ 1,172,646.00 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.
7. Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс 1 мэдээллийг хугацааг хоцроосон байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	4,325.5	2	2,805.9	2	108.0	-	-	3	1,412.6
2	Төсөл, хөтөлбөр										

/мянган төгрөгөөр/

3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИИТ	7	4,325.5	2	2,805.9	2	108.0	-	-	3	1,412.6



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 34/КС10526/99А-2022/14/11А-СА-ОНА Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 10 албан хаагчид нийт 19,997.95 төгрөг /Арван есөн мянган есөн зуун ерэн долоон төгрөг 95 мөнгө/-ийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосон байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэн заалт, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тайлант хугацаанд 10 албан хаагчид цалин олгохдоо нийт 19,997.95 /Арван есөн мянган есөн зуун ерэн долоон төгрөг 95 мөнгө/ төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүйг нягтлан бодогч Б.Мөнхтуулаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Даа.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлүүлж Дархан -Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Л.Нямсүрэн, Нягтлан бодогч Б.Мөнхтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Ж.БЯМБАЖАВ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР

009050117



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 25/1557/05.26/0111-2022/14/НА-ОА Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд эмийн тайлангийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, зарцуулалтын тайлангүй 88,000.00 /Наяан найман мянган/ төгрөгийн эм шаардах хуудсаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтууд, "Эрх бах үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.5-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Тайлант хугацаанд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, хүлээн авсан, өгсөн хүний баталгаажилт байхгүй, гүйцэтгэлийг тайлагнаагүй 88,000.00 /Наяан найман мянган/ төгрөгийн эм зарцуулсныг нягтлан бодогч Б.Мөнхтуулаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Даа.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2.Актын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлүүлж Дархан -Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн Л.Нямсүрэн, Нягтлан бодогч Б.Мөнхтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР  Ж.БЯМБАЖАВ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ш.МӨНХБАЯР

009050120

